

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

**1/26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэг:**

“26.5.Энэ зүйлийн 26.1.1-д заасан мөнгөн тусламжийг сайжруулсан шахмал түлш худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлж болно.”

**2/26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг:**

“26.6.Энэ зүйлийн 26.1.1, 26.1.5, 26.1.7, 26.1.9-26.1.15-д заасан тусламж, хөнгөлөлтийг зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.”

**3/26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэг:**

“26.7.Энэ зүйлийн 26.1.2-26.1.4, 26.1.7, 26.1.8-д заасан хөнгөлөлтийн 80 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 20 хувийг улсын төсвөөс тус тус санхүүжүүлж, жишиг үнэ, олгох журмыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний Зөвлөл батална.”

**2 дугаар зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн” гэснийг “олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөгжлийн” гэж, 33.4 дэх хэсгийн “түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох тэтгэвэртэй нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн урамшуулал олгоно.” гэснийг “Засгийн газраас баталсан журмын дагуу мөнгөн урамшуулал олгоно” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйл болон 26.1 дэх хэсгийн “нийгмийн халамжийн сангаас” гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.6, 26.1.16 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ахмад настны тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

“12.5<sup>1</sup>. Энэ зүйлийн 12.5-д заасан хүндэтгэлийн зардлыг аймаг, нийслэлийн Засаг даргын төсвөөс хариуцна.

13.5. Энэ зүйлийн 8.1.3-д заасан мөнгөн тусламжийг сайжруулсан шахмал түлш худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлж болно.”

**2 дугаар зүйл.** Ахмад настны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “10.1.1,” гэсний дараа “10.1.2-т заасан эрхийн бичгийн үнэ,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.8-д заасан шалгуур, журмыг хангасан” гэдгийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, шалгуур журмын дагуу” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон” гэснийг “нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “10.1.2,” гэснийг “10.1.2-т заасан тээврийн хэрэгслийн нэг талын зардал,” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “нийгмийн халамжийн эсхүл” гэснийг, 8.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 8.1.2-т заасан амралт, сувиллын газрын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага,” гэснийг, 13.2 дахь хэсгийн “үйлчилгээ,” гэснийг 13.3 дахь хэсгийн “8.1.2,” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.** Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй.

“71.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан Монгол Улсын Ерөнхий сайдтай тухайн нутаг дэвсгэрийн хүн ам, өрхийн ядуурлыг бууруулах гэрээ байгуулж ажиллана:

71.2.1. Гэрээнд тухайн жилд ядуурлаас гаргах өрх, иргэний тоо, мэдээллийг тусгах;

71.2.2. ядуурал ихтэй нутаг дэвсгэрийг тогтоож, түүнд чиглэсэн бодлого боловсруулах;

71.2.3. газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор ядуу өрх, иргэнд газар олгох, эзэмшлийн газартаа тариа, ногоо тарих, малжуулах, нэмүү өртөрг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан борлуулахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр хөдөлмөр эрхлэх, тогтмол орлого олох боломжийг бүх талаар дэмжин ажиллах;

71.2.4. нутаг дэвсгэрийн хүрээнд ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах;

71.2.5. доод шатны Засаг дарга нарын ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт тавьж, тайланг дүгнэж, урамшуулах, хариуцлага тооцох;

71.2.6. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан ядуурлыг бууруулах гэрээний биелэлтийн явц, үр дүнг жил бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол улсын Засгийн газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

“12.8. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан аймаг, нийслэлийн Засаг даргын орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлсэн хүн ам, өрхийн ядуурлыг бууруулах гэрээний биелэлт, тайланг жил бүрийн нэгдүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, үр дүнг дүгнэн урамшуулж, хариуцлага тооцож ажиллана.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“4.2.6.нийгмийн халамжийн арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаатай уялдуулан иргэдийн амьжиргааг дээшлүүлэх.”

“30.1.17<sup>1</sup> хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн халамжийн байгууллагын хамтын үйл ажиллагааг иргэдийн амьжиргааг дээшлүүлэх нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх;”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчилсүгэй:

“5.2.Төрийн захиргааны холбогдох байгууллага энэ хуульд заасны дагуу гэр бүлийн эрхийг хамгаална.”

**2 дугаар зүйл.** Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсгийн “урамшуулал” гэснийг “тэтгэмж” гэж, мөн зүйлийн 74.7 дахь хэсгийн “урамшуулалд” гэснийг “тэтгэмжид” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “22 дугаар” гэснийг “14” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “20.2-т” гэснийг “15.2-д” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 18.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авсан” гэснийг “Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн арга хэмжээ болон Хүн амын өсөлтийг дэмжих тухай хуульд заасан тэтгэмж, урамшуулал, хөнгөлөлтөд хамрагдсан,” гэж, 2.2 дахь хэсгийн “нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авч” гэснийг “нийгмийн халамжийн арга хэмжээ, тэтгэмж, урамшуулал, хөнгөлөлтөд хамрагдаж” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны... дугаар сарын  
...ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүүхэд хамгааллын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

“13.5. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэх журам, сургалтын хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.6. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хоол хүнс, хувцас, зөөлөн эдлэл, эм, ариун цэвэр, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын хэмжээг санхүү, төсвийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

13.7. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний төсвийг батлуулах, зарцуулах, үйл ажиллагаанд хяналт тавих журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.** Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг доор дурьдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

“13.4. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулах шийдвэрийг хамтарсан баг, нийгмийн ажилтны санал, дүгнэлтийг үндэслэн Аймаг, дүүргийн Засаг дарга гаргах бөгөөд гарсан шийдвэрийн хэрэгжилтэд Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан хяналт тавина.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

“13.2.Энэ зүйлийн 13.1.4-д заасан төрийн бус байгууллагыг санхүүжүүлэх зардлыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусгана.

**2 дугаар зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

“40.1.Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн холбогдох арга хэмжээнд хохирогчийг хамруулна.”

**3 дугаар зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.14, 9.1.15 гэсэн заалт нэмсүгэй:

#### 1\ 9 дүгээр зүйлийн 9.1.14 дахь заалт

“9.1.14.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.2-26.1.4, 26.1.7-д заасан хөнгөлөлтийн 80 хувь;”

#### 2\ 9 дүгээр зүйлийн 9.1.15 дахь заалт

“9.1.15.Ахмад настны тухай хуулийн 8.1.1, 10.1.2-д заасан эрхийн бичгийн үнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЛДАР ЦОЛТОН АХМАД НАСТАНД НЭМЭГДЭЛ, ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “доор дурдсан” гэснийг “Ахмад настны тухай хуульд заасан” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1-5.4.3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр баталсан Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ